



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт Ус- Дулаан ААТҮГ 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: О.Барчидгүнсэн
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	8
3.6 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ
СУМЫН ТҮМЭНЦОГТ УС ДУЛААН ААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Б.ЛЭГЗИЙМАА ТАНАА

2022.03.22 № 155
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Түмэнцогт ус дулаан” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Түмэнцогт ус дулаан” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Түмэнцогт ус дулаан” ААТҮГ-т 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 300.0 сая төгрөгийн өртөгтэй “Халаалт, цэвэр бохир усны шугам шинэчлэх ажил”, аймгийн ОНХС-ын эх үүсвэрээр 99.8 сая төгрөгийн өртөгтэй “Усан халаалтын KWR-1.8-095-ОУР” маркийн халаалтын тогоо шинээр худалдан авч бүртгэл тайланд илэрхийлсэн байна.

Аудитын гол асуудал

“Түмэнцогт ус дулаан” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаар 130.8 сая төгрөгийн алдагтай гарсан байна. Энэ нь нүүрс, түлш шатахууны үнэ 30-50 хувь өссөн, айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт, цэвэр ус ариутгах татуургын үйлчилгээний төлбөр 2015 оноос хойш өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудлын хэсэг

“Түмэнцогт ус дулаан” ААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Аймгийн ИТХ-аар батлуулахаар хүргүүлсэн боловч батлаагүй бөгөөд захиралтай байгуулсан гэрээг дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,880,431.85	20,656,748.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	504,023.14	1,886,376.33
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	504,023.14	1,886,376.33
31210	Төгрөг	504,023.14	1,886,376.33
31213	Арилжааны банк дахь харилцах	504,023.14	1,886,376.33
33	АВЛАГА	12,054,439.20	6,640,699.66
33401	Дансны авлага /ТӨҮГ/	0	3,334,689.72
33500	Бусад авлага	12,054,439.20	3,306,009.94
33510	Байгууллагаас авах авлага	12,054,439.20	3,306,009.94
35	БАРАА МАТЕРИАЛ	10,321,969.51	12,129,672.67
35400	Хангамжийн материал	10,321,969.51	12,129,672.67
35420	Аж ахуйн материал	10,321,969.51	12,129,672.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,562,832,379.10	1,820,414,830.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,562,832,379.10	1,820,414,830.28
39200	Биет хөрөнгө	1,548,640,379.10	1,806,222,830.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,692,929,989.86	1,992,929,989.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-359,011,840.37	-450,530,017.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	107,000,000.00	107,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101,513,889.01	-107,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	146,785,818.00	246,753,818.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,424,251.31	-104,692,853.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,324,124.00	174,324,124.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-106,223,582.09	-123,610,954.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	93,882,138.00	93,882,138.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,108,127.98	-22,833,413.50
39300	Биет бус хөрөнгө	14,192,000.00	14,192,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,192,000.00	14,192,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,585,712,810.95	1,841,071,578.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	63,382,779.82	449,584,963.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	63,382,779.82	449,584,963.67
41300	Өглөг	24,100,652.06	46,248,973.44
41360	Бусад өглөг	24,100,652.06	46,248,973.44
41361	Байгууллагад төлөх өглөг	13,746,695.39	30,227,609.99
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	10,353,956.67	16,021,363.45
41400	Урьдчилж орсон орлого	39,282,127.76	403,335,990.23
41440	Бусад урьдчилж орсон орлого	39,282,127.76	403,335,990.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,522,330,031.13	1,391,486,615.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,522,330,031.13	1,391,486,615.27
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,277,836,426.90	1,277,836,426.90
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,277,836,426.90	1,277,836,426.90
51200	Хуримтлагдсан үр дүн	-1437262385.63	-1,568,105,801.49
51210	Өмнөх үеийн үр дүн	-1346244517.67	-1,437,262,385.63
51220	Тайлант үеийн үр дүн	-91,017,867.96	-130,843,415.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,681,755,989.86	1,681,755,989.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,585,712,810.95	1,841,071,578.94

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,564,864.09	370,590,047.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358,564,864.09	370,590,047.82
120	Нийтлэг татварын бус орлого	358,564,864.09	370,590,047.82
120009	Бусад орлого	10,000,000.00	500,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	348,564,864.09	370,090,047.82
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	0	155,752,752.22
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	449,482,136.82	345,680,711.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,482,136.82	345,680,711.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,482,136.82	345,680,711.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	314,488,007.62	345,680,711.46
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	198,635,906.55	0
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	94,321,237.92	343,434,311.46
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	17,728,010.15	86,600.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	3,802,853.00	2,159,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,994,129.20	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,994,129.20	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-90,917,272.73	-130,843,415.86
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,595.23	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	100,595.23	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-91,017,867.96	-130,843,415.86

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,346,244,517.67	1,613,347,899.09
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,346,244,517.67	1,613,347,899.09
Тайлант үеийн үр дүн	0	0	-91,017,867.96	-91,017,867.96
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,437,262,385.63	1,522,330,031.13
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,437,262,385.63	1,522,330,031.13
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,437,262,385.63	1,522,330,031.13
Тайлант үеийн үр дүн	0	0	-130,843,415.86	-130,843,415.86
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,277,836,426.90	1,681,755,989.86	-1,568,105,801.49	1,391,486,615.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	394,080,878.63	410,567,369.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,080,878.63	410,567,369.84
120	Нийтлэг татварын бус орлого	394,080,878.63	410,567,369.84
120009	Бусад орлого	10,000,000.00	16,744,800.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	384,048,418.63	393,822,569.84
120015	Даатгалын нөхвөрөөс хилээн авсан мөнгө /ТӨҮГ/	32,460.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,790,431.38	414,185,016.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,790,431.38	414,185,016.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,790,431.38	414,185,016.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,491,737.01	142,296,667.47
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	110,491,737.01	142,296,667.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,254,570.21	43,993,562.01
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	36,254,570.21	43,993,562.01

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,911,587.27	88,914,079.02
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	90,911,587.27	88,914,079.02
2104	Хангамж, бараа материалын зардал	89,740,150.56	110,580,270.61
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	52,516,517.83	66,914,058.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	37,223,632.73	43,666,212.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,392,386.33	28,400,437.54
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	0	1,940,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	66,311,686.33	26,163,462.54
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0	210,375.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	80,700.00	86,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	290,447.25	-3,617,646.81
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	5,000,000.00
14	Бусад эх үүсвэр	0	15,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	15,000,000.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	10,000,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	0	10,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	290,447.25	1,382,353.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	213,575.89	504,023.14
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	504,023.14	1,886,376.33

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын зорилго нь тус сумын хэрэглэгчдийг дулаанаар хангах, унд ахуйн чанар стандартад тохирсон усыг олборлон түгээх, хэрэглээний явцад гарсан бохир ус, хог хаягдлыг татан зайлуулах ажлыг хэвийн явуулах” зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх үйл ажиллагаа, ус хуримтлуулах, ариутгах, төвлөрсөн ус хангамжийн үйлчилгээ, хог хаягдлыг татан зайлуулж, нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх, гэрээ, төлбөрт үндэслэн хийгдэх дулааны болон ус сувгийн шугам сүлжээ, сантехникийн засвар үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх, ус хуримтлуулах, ариутгах, төвлөрсөн ус хангамж үйлчилгээ, гэрээ төлбөрт үндэслэн хийгдэх дулааны болон ус сувгийн шугам сүлжээ, сан техникийн засвар үйлчилгээ үзүүлэх чиглэлтэй байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Мөн айл өрхийн халаалтын хөлсийг 2015 оноос хойш нэмэгдүүлээгүй 1м2 -ийн үнэ 420 төгрөгөөр мөрдөж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 28 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 2.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон

өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд бүртгэлийг сайжруулж анхан шатны бүх худалдан авалтыг сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлэн НӨАТ баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас бүрэн авч ажиллажээ.

Дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 20 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 20 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 979.9 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагыг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Түмэнцогт ус дулаан ААТҮГ -ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 255,358.7 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	504.0	1,886.3	1,382.3
Авлага	12,054.4	6,640.7	-5,413.7

Бараа материал	10,321.9	12,129.6	1,807.7
Үндсэн хөрөнгө	1,562,832.3	1,820,414.8	257,582.4
Нийт хөрөнгө	1,585,712.8	1,841,071.5	255,358.7
Өр төлбөр	24,100.6	46,248.9	22,148.3
УОО	39,282.1	403,335.9	364,053.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,522,330.0	1,391,486.6	-130,843.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,585,712.8	1,841,071.5	255,358.7

Харилцахын үлдэгдэл 1,886.3 мянган төгрөг болж өссөн нь орлогоос харилцах дансанд үлдсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 6,640.7 мянган төгрөг болж өмнөх оноос 5,413.7 мянган төгрөгөөр буурсан нь халаалт дулааны авлага цаг хугацаандаа төлөгдсөн нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,807.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь хангамжийн материал худалдан авсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,820,414.6 мянган төгрөг болж өмнөх оноос 257,582.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дулааны шугам сүлжээ 300,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас уурын зуухны тогоо 99,868.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө данснаас хассан болон элэгдлийн зардлаар буурчээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 49,648.5 мянган төгрөг болж 22,148.3 мянган төгрөгөөр өссөн нь тээврийн хөлс, шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотой үүссэн байна. Мөн айл өрхийн халаалтын хөлсийг 2015 оноос хойш нэмэгдүүлээгүй 1м² -ийн үнэ 420 төгрөгөөр мөрдөгдөж байгаа нь өр төлбөр үүсэхэд нөлөөлж байна.

3.6 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2022 онд Аймгийн засаг даргатай контрактын гэрээ байгуулаагүй ажиллажээ.

Тус байгууллага 2022 онд зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, бусад эх үүсвэрийг батлуулахаар зохих шатны байгууллагад хүргүүлсэн боловч батлаагүй байна.

Тайлант оны нийт орлогыг 338,779.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 338,779.0 мянган төгрөгөөр, ашиг алдагдалгүй байхаар тогтоосон байна. Аймгийн орон нутгийн өмчийн газарт тайлангаа жил бүр тайлагнадаг боловч ИТХ-аас баталж өгөөгүй байна

Гүйцэтгэлээр 370,090.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 500,933.4 мянган төгрөгийн зардал гарган, 130,843.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь урьдчилж орсон орлогоо бүртгэсэн хөрөнгийн тухай жилийн элэгдлийн зардал, нүүрс, түлш шатахууны үнэ 30-50 хувь өссөн, айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт, цэвэр ус ариутгах татуургын үйлчилгээний төлбөр 2015 оноос хойш өөрчлөлт ороогүй байна.

Нийт орлогын гүйцэтгэл 370,090.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 31,311.0 мянган төгрөг буюу 9.2 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 500,933.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 162,154.4 мянган төгрөг буюу 47.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 130,843.4 мянган төгрөг байна. Энэ нь нүүрс, түлш шатахууны үнэ 30-50 хувь өссөн, айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт, цэвэр ус ариутгах татуургын үйлчилгээний төлбөр 2015 оноос хойш өөрчлөлт ороогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ -ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ААТҮГ-ийн үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлаас 345,662.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,184.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,840.0 мянган төгрөгөөр өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8² заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил³ илэрснээс алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1 Үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

5.1.1 Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно./, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 / үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;/ дахь заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

² бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг харгалзан цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулах

Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

5.1.2 Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй, мөн бусад мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁴ заасныг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн	1	0						1	0
Дүн	1	0						1	0

⁴ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;